



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251.
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

д023. 05. 23 № 01/9412
танай -ны № -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

Г Зөвлөмж хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Авлигатай тэмцэх таван ажиллагаа”-ны “Шилэн ажиллагаа”-ны хүрээнд Авлигатай тэмцэх газраас төрийн тусгай чиг үүрэгтэй байгууллагаас бусад төрийн байгууллагын тээврийн хэрэгсэлд төрийн өмч хөрөнгө болохыг илтгэх тэмдэг, тэмдэглэгээг байршуулах ажлын явцыг хянан үзэж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т зааснаар “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэсэн заалтын дагуу Засгийн газрын 2022 оны 204 дугаартай тогтоолын 6-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулах”, Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 36 дугаартай тэмдэглэлээр тус тус Ерөнхий сайдад танилцуулан чиглэл авахыг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан байна.

Монгол Улсын авто тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийн санд одоогийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй 1728 байгууллагын 14717 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Зам, тээврийн хөгжлийн яамнаас авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг 1 дүгээр хэсгийн ерөнхий шаардлага буюу MNS4410-1:2002¹ стандартыг баримталж төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд дэвсгэр хар, цэнхэр өнгөтэй, хүрээ болон дугаар, үсэг нь цагаан өнгөтэй байхаар баталжээ.

Тээврийн хэрэгслийн улсын дугаар хэвлэхэд хос дугаар дунджаар 45 мянган төгрөгийн үнэтэй ба төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн дугаарыг солиход ойролцоогоор 588.7 сая төгрөгөөс 735.8 сая төгрөгийн хэмжээний төсөв шаардлагатай гэсэн тооцоог Зам, тээврийн хөгжлийн яамнаас гаргасан байна.

Төрийн байгууллагын тээврийн хэрэгсэлд хэрэглэгдэх улсын дугаар нь аль байгууллагын автомашин болохыг тодорхойлох боломжгүй, мөн өөр дугаараар сольж болох, олон нийтийн зүгээс төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, улсын дугаар үйлдвэрлэгч нарын ашиг сонирхолд нийцүүлсэн гэх хардлага төрөх, шүүмжлэл дагуулах эрсдэлтэй байна.

Уг асуудлыг төрийн байгууллагын тээврийн хэрэгсэлд тухайн байгууллагын лого болон ямар байгууллагын авто тээврийн хэрэгсэл болохыг илэрхийлсэн таних тэмдэг бүхий салдаггүй стикерийг байршуулсан, илүү хямд төсвөөр шийдэх гарц байна. Энэ нь төрийн байгууллагын нийт 14.717 тээврийн хэрэгсэлд ойролцоогоор

7,5 саяаас 10 сая төгрөг буюу Зам, тээврийн хөгжлийн яамны тооцоолсон зардлаас 10 дахин бага зардлаар шийдэх боломжтой юм.

Иймд төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчил гарах, иргэд, олон нийтийн бухимдлыг төрүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд аль болох хэмнэлттэй, хямд төсөв, хялбар байдлаар асуудлыг шийдэх боломжийг судлан үзэн шийдвэрлэхийг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу зөвлөж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2023 оны 06 дугаар сарын 30-ны дотор хариу ирүүлнэ үү.

Хувийг, Зам тээврийн хөгжлийн яаманд.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА

